

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 11/18

Номгон

“Улаанбаатар хотоос тус аймгийн харьяат”
иргэдийг татан авах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/6, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Шадар Сайдын 2020 оны 156 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлан тусгай зөвшөөрөл бүхий автомашин хот хооронд явж, эрүүл мэнд, буян номын шалтгаантай иргэд зохих зөвшөөрлийн дагуу замын хөдөлгөөнд оролцож байгаатай холбогдуулан Улаанбаатар хотод саатсан тус аймгийн иргэдийг татан авах ажлыг тусгай горимын дагуу тээврийн хэрэгсэл гарган 7 хоногт 1 автобус явуулахаар тооцож, зорчигчдыг зөвхөн Баянхонгор аймгийн иргэн, оршин суугаа хаягийг үндэслэн сонгож, тусгай хуваарь гарган зохион байгуулсугай.

2.Тусгай үүргийн автобус явуулж, иргэдийг сонгох түр журмыг хавсралтаар баталж, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн (С.Амармөнх)-д, зорчих иргэдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажлыг аймгийн Онцгой комиссын “Өргөдөл, гомдол шийдвэрлэх шуурхай ажлын хэсэг”-ийн дарга Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Б.Оюутболд нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 01
дүгээр сарын 15-ны өдрийн А/48

дугаар захирамжийн
схавьраг



ТУСГАЙ ҮҮРГИЙН АВТОБУСААР ЗОРЧИХ ИРГЭДИЙГ ТАТАН АВАХ, ӨРГӨДӨЛ ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВЧ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлан тусгай зөвшөөрөл бүхий автомашин хот хооронд явж, эрүүл мэнд, буян номын шалтгаантай иргэд зохих зөвшөөрлийн дагуу замын хөдөлгөөнд оролцож байгаатай холбогдуулан Улаанбаатар хотод саатсан тус аймгийн иргэдийг татан авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Улаанбаатар хотоос ирэх иргэдийн хүсэлтийг аймгийн Онцгой комиссын "Шуурхай штаб" дээр bhrshtab@gmail.com хаягаар өдөр бүр хүлээн авч цахим хэлбэрээр явагдах бөгөөд тус аймгаас Улаанбаатар хот руу зорчих Улаанбаатар хот болон бусад аймгийн иргэдийн хүсэлтийг аймгийн Авто тээврийн төв дээр бичгэн хэлбэрээр авч, тархвар зүйн асуумжийн хуудсыг үндэслэн зорчих тасалбар олгоно.

Хоёр. Улаанбаатар хотоос ирэх иргэдийн өргөдөл,
хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

2.1 Иргэд өргөдөл хүсэлт гаргахдаа иргэний үнэмлэх, Баянхонгор аймагт яг одоо оршин суугаа хаягийн тодорхойлолтыг хавсаргах бөгөөд тухайн зорчигч зөвхөн тус аймгийн иргэн байна.

2.2 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг 7 хоног бүрийн "Даваа" гарагт аймгийн Онцгой комиссын "Өргөдөл, гомдол шийдвэрлэх шуурхай ажлын хэсэг"-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, тухайн өдөр холбогдох утасны дугаараар ирэх 40 иргэнд 3 хоногийн өмнө хариу мэдэгдэнэ.

2.3 Онцгой комиссын "Шуурхай штаб"-ын 92193300 тусгай дугаараас мэдээг тухайн иргэнд өгч, нэрийг аймгийн Авто тээврийн төвд хүргүүлж баталгаажуулна.

Гурав. Зорчигчийн эрх, үүрэг.

3.1 Зорчих эрх үүссэн иргэн Авто тээврийн төвийн 70442202 дугаараар зорчих тасалбараа захиална.

3.2 Улаанбаатар хотоос тус аймагт зорчих хүсэлтэй иргэн нь аймгийн Онцгой комиссын "Шуурхай штаб"-аас мэдэгдсэн тохиолдолд хоног хугацааг зөв тооцож, дүүргүүдэд байрлах шинжилгээ авах цэгт очиж PCR-ын шинжилгээ өгч, хариу "Сөрөг"

гарсан тохиолдолд, уг шинжилгээний бичгийг хүчинтэй хугацаанд зорчих хөдөлгөөнд оролцоно.

3.3 Хот хооронд зорчих иргэн заавал өөрийн биед иргэний үнэмлэхийг авч явна.

3.4 Зөвхөн цахимаар бүртгэл нь баталгаажсан иргэд тусгай үүргийн автобусанд суух бөгөөд бусад тохиолдолд иргэн хүлээн авахгүй.

3.5 Тусгай үүргийн автобус нь хот хоорондын хөдөлгөөнд оролцож эхэлсэн цагаас эхлэн авто зам дагуух төвлөрсөн суурин газар, цайны газруудад зогсохгүй тул иргэд замд хэрэглэх хүнсний асуудлаа өөрсдөө хариуцна.

3.6 Тусгай үүргийн автобусаар зорчиж ирсэн иргэдийг харьяа сумдуудад шууд шилжүүлэх, бөгөөд багийн дарга нарын хяналтанд гэрийн ажиглалтад 7 хоногийн хугацаанд халдвар хамгааллын дэглэмийн дагуу оруулна.

3.7 Зорчих эрх үүссэн иргэд автобус хөдлөхөөс 30 минутын өмнө ирж, бичиг баримтаа шалгуулан тухайн тээврийн хэрэгсэлд суухад бэлэн болсон байна.

Дөрөв. Зорчих чиглэл, хугацаа,

4.1 Баянхонгор аймгаас Улаанбаатар хотын чиглэлд аймгийн Авто тээврийн төвөөс 7 хоног бүрийн "Лхагва" гарагт 08:00 цагаас 1 автобус, 40 зорчигч, Улаанбаатар хотоос Баянхонгор аймгийн чиглэлд Сонгинохайрхан зорчигч тээврийн "Драгон" төвөөс 7 хоног бүрийн "Пүрэв" гарагт 08:00 цагаас 1 автобус, 40 зорчигчтойгоор тус тус замын хөдөлгөөнд оролцоно.

Тав. Хяналт, хариуцлага

5.1 Ажиглалтад байгаа иргэдийн өдөр тутмын хөдөлгөөнд аймгийн Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, Эрүүл мэндийн газар болон сумдын Засаг даргын Тамгын газраас хяналт тавьж ажиллана.

5.2 Баянхонгор аймгаас Улаанбаатар хот руу зорчигчид 30 хоногийн хугацаанд тус аймагт буцаж ирэхийг хориглоно.

5.3 Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлээгүй, хуурамч материал (нас барсны гэрчилгээ, зорчигчийн асуумж судалгаа тухай эмчийн гарын үсэг, тэмдэггүй гэх мэт бусад) бүрдүүлсэн иргэнийг холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлж хариуцлага тооцно.

-----oO-----